

ХӨГЖМИЙН СУРГАЛТЫН ЯВЦАД СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДИЙН ДУУЛАХ СОЁЛЫН СУУРЬ БҮРЭЛДЭХ НЬ

Ц.Эрдэнэтуяа, магистр, МУБИС

Аннотация

Данная статья посвящена проблеме формирования вокально-хоровой культуры дошкольников на музыкальных занятиях.

В статье рассматриваются теории, точки зрения и методические рекомендации ученых по организации учебного процесса обучения детей пению и подбора песенного репертуара на музыкальных занятиях в дошкольных учреждениях, определению значимости пения и развитию певческих навыков у детей дошкольного возраста. *Даны определения сущности и содержания вокально-хоровой культуры дошкольников.* Автор приходит к выводу, что формирование основ вокально-хоровой культуры дошкольников прямо может зависеть от знания и навыков музыкального руководителя.

Автором был проведен опрос музыкальных руководителей для оценки их знаний и понятий музыкальных руководителей в работе с детьми, по подбору песенного репертуара, гигиене и охране певческого голоса детей, определению диапазона детских голосов.

В целях оказания помощи музыкальным руководителям при организации учебного процесса обучения детей пению, в статье приведены некоторые рекомендации и предложения по работе с детьми.

Түлхүүр үг

Дуулах соёл, дуулах ур чадвар, хүүхдийн хоолойн эрүүл ахуй, дууны урын сан, хөгжмийн сургалт, хөгжмийн багш.

Удиртгал

Хүүхдийн хөгжил төлөвшилд дуу хөгжим онцгой байр суурийг эзэлдэг. Хүүхдийн авьяас чадварт эцэг, эхийн анхаарал хандлага чухал хэдий ч хөгжмийн соёлыг төлөвшүүлэх, авьяас чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэхэд мэргэжлийн хөгжмийн багшийн нөлөө их байдаг.

Цэцэрлэгийн хөгжмийн багш нь илүү хариуцлага хүлээдэг хэмээн үзэж болно. Учир нь сургуулийн өмнөх нас нь хүүхдийн өсөлт, хөгжил төлөвшлийн хамгийн мэдрэмтгий эрчтэй хөгжлийн үе юм. Гэвч зөв удирдан чиглүүлж чадаагүйгээс хүүхэд бүрийг хөгжүүлж, олон авьяастан төрүүлэх боломжийг алддаг. Бага насны хүүхдийн хөгжмийн үйл ажиллагааны чиглэлийг эрдэмтэд (Радынова, Комиссарова, 2011, х.115) дараах байдлаар ангилсан. Үүнд:

- Хөгжим сонсох
- Хүүхдийн хөгжмийн гүйцэтгэл (дуулах, хөгжимдөх, бүжиглэх)
- Хүүхдийн бүтээлч үйл (дуулах, хөгжимдөх, бүжиглэх үеийн бүтээлч байдал)
- Хөгжмийн тухай ойлголт
- Хөгжимт тоглоомын үйл

Эдгээр хөгжмийн үйлийг зөв зохион байгуулсны үр дүнд хүүхдийн хөгжмийн авьяас чадвар хөгжиж, хөгжмийн соёлын суурь бүрэлдэж, хүүхдийн ерөнхий хөгжил төлөвшилд эерэг нөлөө Оросын эрдэмтэн Б. Теплов “Хөгжмийн авьяас нь тухайн үйлийг хийх явцад бүрэлдэн бий болдог” хэмээн үзсэн (1985). Хүүхдийн хөгжмийн үйл

ажиллагаанаас дуулах нь хүн бүрд хамгийн хялбар юм шиг санагддаг. Удаан хугацааны турш буюу өдөр бүр дуулсан ч дуулах чадварын хувьд ямар нэгэн өөрчлөлт гарахгүй тохиолдол байдаг. Хэрэв зөв ажиллавал богино хугацаанд ч илүү үр дүнд хүрэх боломжтой юм.

Тиймээс хөгжмийн багш хүүхэд бүрийн хоолойн онцлогийг харгалзан дуулах чадварыг хөгжүүлэх, үүгээр дамжуулан дуулах соёлд сургаж, хүүхдийн хөгжил төлөвшилд хэрхэн нөлөөлөх тухай ойлголтыг зайлшгүй мэдэж байх шаардлагатай.

Багш сургалтыг зохион байгуулахдаа дараах ойлголтын талаар мэдлэгтэй байж, түүнийгээ сургалтад ашиглаж чадвал хүүхдийн дуулах үйл ажиллагааг үр дүнтэй зөв зохион байгуулах боломжтой төдийгүй хүүхдийн дуу хоолойн онцлог дуугаралт, хоолойн царааг тодорхойлох, хоолойн эрүүл ахуйг хамгаалах, хүүхдийн урын санг зөв сонгох, дуулах ур чадварыг хөгжүүлэх бүрэн боломжтой билээ.

Бид энэхүү өгүүлэлдээ багш нарын хүүхдийн дуулах үйлийг зөв удирдан зохион байгуулах ойлголт ямар байгааг тодруулах зорилго тавив.

- Энэхүү судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:
- Дуулах үйл ажиллагааны ач холбогдол, хүүхдийн хоолойн онцлог, дуулах дадал

чадварын тухай зарим эрдэмтдийн үзэл онолыг тоймлон дүгнэж харьцуулах;

- Хөгжмийн багш нарын дунд асуудлыг тодруулах судалгаа хийх;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн дуу-найрал дууны соёлын талаарх ойлголтыг тодорхойлох;
- Хөгжмийн сургалтаар хүүхдэд дууны хичээлийг зохион байгуулах, хүүхэдтэй ажиллах аргачлал, дууны урын сангийн сонголт хийх зарчмын талаарх арга зүйн зөвлөмжийг боловсруулах гэх мэт.

Энэхүү судалгаанд асуулга, ярилцлага, эх зохиол судлах, дүн шинжилгээ, жишиж харьцуулах арга зэргийг ашиглаж, тоон мэдээллийг боловсруулж нэгтгэн дүгнэсэн болно.

Дуулах үйл хүүхдийн хөгжил төлөвшилд нөлөөлөх нь

Хөгжмийн урлагтай харьцах нь хүүхдийн гоо сайхан, сэтгэл хөдлөлийн мэдрэмж, оюун ухаан, бие бялдар хүүхдийн ерөнхий хөгжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг олон эрдэмтэд судалгаандаа дурдсан байдаг. Хүн болж төлөвшинө гэдэг нь бусадтай адил байна гэсэн үг биш бөгөөд өөрийн гэсэн давтагдашгүй өвөрмөц хувийн зан чанар, сэтгэл мэдрэмж, хүсэл сонирхол, хэрэгцээтэй байна гэсэн үг юм.

Хөгжмийн ачаар хүүхдийн тархины мэдрэлийн эсүүдийн холбоосны тоо нэмэгдэж хүүхдийн ярианы чадвар сайжирдаг байна. Мөн суралцах арга барилаа олж авах, уншиж сурах, математикийн бодлогыг ойлгох, юмыг амархан цээжлэхэд тус болдог. Харин олон нийтийн дунд амьдрах, уян хатан чанар, харсан сонссоноо тогтоох, гоо сайхан мэдрэмжтэй болох, бодол санаагаа илэрхийлэх стресст автахгүй байх, өөрийн дотоод дуу хоолой, бодлоо сонсож, түүндээ итгэх гэсэн чухал чанаруудыг хөгжим сонсож, хөгжмийн урлагтай холбогдсоноороо хөгжүүлж болно (Дон, Кампбелл, 2010, х.15).

Хөгжмийн урлагийн нэгээхэн хэсэг болох дуулах үйл нь бага насны хүүхдийн хамгийн дуртай үйлүүдийн нэг юм. Дуулах үйл ажиллагааны үед амьсгаа авах үйлдэл нь хүүхдийн цусны эргэлтийг сайжруулан, уушгины ажиллагаа, бие бялдын ерөнхий хөгжилд сайнаар нөлөөлдөг болохыг физиологич В.М.Бехтерев, И.П.Павлов нар судалгаандаа дурджээ.

Дуулах дадалтай хүүхдийн хоолой нь секундэд 70-3000 хооронд хэлбэлздэг. Энэ хэлбэлзэл нь хүүхдийн бүх организмд нэвтрэн цусны эргэлтийг сайжруулж эсийг цэвэршүүлдэг байна. Дархлааны системийг удирддаг гавалын яс, тархинд хэлбэлзлийн доргилтыг өгч сайнаар нөлөөлдөг төдийгүй хүний дотоод эрхтнийг

дотроос нь доргилт өгч эрүүлжүүлдэг онцлогтой. Дуулах явцад дуу авианы эгшгийн 20 хувь нь гадагшаа гарч, 80 хувь нь дотроо үлдэж, эд эрхтнүүдийг идэвхтэй ажиллахад хүргэдэг гэсэн сонирхолтой судалгаа байдаг. Амьсгаа авах үеийн хэвлийн хэсгийн агшилт нь элэгний үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж цөсийг байнга хөдөлгөөнд оруулж, гэдэс дотрыг цэвэрлэх ашиг тустай гэдгийг судалгааны явцад эрдэмтэд тогтоожээ (Буланов, 2003, х.16).

Дуулах урлагийг амьсгааны урлаг ч гэж нэрлэдэг. Зөв амьсгаа нь уушиг, амьсгалын замын өвчнөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм. Дуучид хэвлийгээр амьсгаа авах үед чээжний хэсгийг суллан нурууны булчингуудыг бэхжүүлдэг байна.

Германы Геттингийн Кристофрадад хавдартай болон сэтгэцийн өвчтэй хүүхдүүдийг дуулах аргаар эмчлэх боломжийг нэг бус удаа ажигласан байна. Эрдэмтэн В.Боссингер хэлэхдээ “Заримдаа дуу нь антидепрессант болдог. Найрал дуунд дуулж буй сэтгэцийн өвчлөлтэй хүмүүст дуу нь эерэг нөлөө үзүүлж байна” гэжээ. Дуулж чаддаг эсэхээс үл хамааран дуулах нь хүнд олон эерэг өөрчлөлтийг авчирдаг байна. Мөн хүн дуу дуулснаар сэтгэл хөдлөлөө илэрхийлж, стресс дарамтаас ангижрах боломжтой юм. Дуулах нь мэдрэлийн системийг бэхжүүлж, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг хөгжүүлдэг байна. Дэлхийд өвчнийг дуугаар эмчлэх, сэтгэл засах олон төвүүд байгуулагдаж судалгаа шинжилгээг идэвхтэй явуулж байна (Sing Dich Gesund).

Дуулах үйл ажиллагаа нь хүүхдийн оюун ухааны хөгжилд чухал чадварыг төлөвшүүлдэг төдийгүй анхаарал, ажиглалт хөгждөг юм. Хүүхэд дуу дуулахдаа сонсонгоо аялгууны хөдөлгөөн, хөгжмийн хамсраа, илэрхийлэх аргачлал, бүтэц, дууны шүлэг зэрэгт дүн шинжилгээ хийдэг. Өөрийн ажиглалтаар олон зүйлийг мэдэж авахын зэрэгцээ багшийн зааж сургасан зүйлийг цээжлэх, давтах, эргэцүүлэн бодох гэх мэт олон үйлдэл нь хүүхдийн оюун ухааны хөгжилд ач холбогдолтой байдаг. Давтаж цээжлэхээс гадна хүүхэд сурсан мэдсэн дээрээ үндэслэн аялгуу, хэмнэл зохиомжлон дуулах зэрэг нь хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлдэг байна.

БНХ-ийн хоолойн цараа, дуулах соёл

Хөгжмийн багш дуулах үйл ажиллагааны ач холбогдол, хүүхдийн хөгжил төлөвшилд хэрхэн нөлөөлөхийг мэдэхээс гадна хүүхдийн хоолойн онцлог, дууны урын санг сонгох, дуулах дадал чадвар, дуулах үйл ажиллагааг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаар мэдлэг, чадвартай байх нь зүйтэй.

Хүүхдийг дуулахад оролцдог эрхтнүүд маш эмзэг, гүйцэд хөгжөөгүй байдаг. Тиймээс хүүхдийн хоолойг хамгаалах нь багшийн үүрэг билээ.

Эрдэмтдийн судалж тогтоосноор ихэнх хүүхдийн хоолойн цараа тухайн насандаа ижил төстэй байдаг байна (Мерзлякова, 2014,х.4): 2-3 нас: ми¹-ля¹

3-4 нас: ми¹-си¹

4-5 нас: ре¹-си¹ (до²)

5-6 нас: ре¹- до²

6-7 нас: до¹- до²

Зураг 1

I октавын до – II октавын до нот (до¹- до²)



Судлаач Н.Д.Орлова хүүхдийн хоолойн ажлын цараа буюу “илүү дуугаралттай” хэсэг нь I октавын ми - I октавын си гэж тодорхойлсон байна. Хүүхэд үүнээс дээд болон доод өнгийг дуулах боломжтой ч энэ хэсэгт дуулахад илүү тохиромжтой сайн дуугарч чаддаг байна. 2 болон 6 настай хүүхдийн дуулах дууны цараа өөр гэдгийг багш анхаарч ажиллавал хүүхдийн хоолойн өвчлөл, гэмтлээс хамгаалж чадна. Мөн хүүхдийн хоолойн цараа тэдний хувийн онцлогоос хамааран өөр өөр байдаг. Оросын эрдэмтэн Л.А.Венгрус судалгааны явцдаа хүүхдүүд 1-2 өнгийн хоолойн цараатай ч байж болохыг тогтоосон. Энэ өнгөнүүд нь I октавт эсвэл бага октавт ч байж болно. Иймээс хоолойн царааг хөгжүүлэх “44 алхам”-ыг боловсруулсан байна. Багш дууны сургалт явуулахын өмнө хүүхэд тус бүрийн хоолойн цараа ямар байгааг тодорхойлон дуулах боломжийг нь харгалзан дууны уран бүтээлийг сонгох нь зүйтэй.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн дуу-найрал дууны соёл гэдэг нь дараах элементүүдээс бүрдсэн нэгдмэл ойлголт юм.

- 1) дуу-найрал дуу дуулах сэдэл, сонирхол;
- 2) мэдлэг: дуулах үеийн онцлог болон дуугаар хичээллэх үеийн дүрэм; монголын болон бусад орны дууны уран сан, бүтээлийн тухай мэдэх; хөгжмийн үндсэн ойлголтын тухай мэдэх;
- 3) чадвар: дуу-найрал дууны дараах энгийн чадваруудыг эзэмших: дууны аялгууны өндөрлөгийг зөв дуулах; нэг октаваас багагүй

хоолойн царааг эзэмших; дуулах үеийн амьсгаа зөв авах, гаргах, зарцуулах; зөөлөн дуулж эхлэх; дууны бүтцийг харгалзан дуулах; үг хэллэг тод, зөв дуудах; хэмнэлийг мэдрэх; дууны утга санааг харгалзан илэрхийлэлтэй дуулах;

- 4) дадал: дууны шинж төрхийг тодорхойлж шүлгийн утга санааг ойлгох; өөрийн болон бусдыг дуулах үед буруу зөвийг ялгах; дууны хүчдэл, хурд, дууны өнгийг харгалзан хамтран нийлэмжтэй дуулж, байнга найрал дууны ерөнхий дуугаралтыг сонсох.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн дуу-найрал дууны соёл бүрэлдэхэд тодорхой зарчмыг харгалзан зохион байгуулах нь үр дүнтэй байх боломжтой:

- а) Монголын дуу-найрал дууны хөгжлийг дэлхийн хөгжмийн урлагийн хөгжилтэй нэгдмэл ойролцоо болгоход анхаарлаа хандуулах;
- б) хүүхдийн хөгжмийн бусад үйл ажиллагааг дуу-найрал дууны сургалт руу чиглүүлэх
- в) бага насны хүүхдийн сэтгэлзүй, бие бялдрын хөгжлийг харгалзах;
- г) дуу-найрал дууны сургалтын явцад хөгжмийн сонсголыг хөгжүүлэхэд анхаарах;
- д) ерөнхий сургалтын зарчмууд болох нээлттэй, сайхан сэтгэл, сэтгэл хөдлөл, бүтээлч чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажиллах зэргийг дурдаж болно.

Дээрх зарчимд тохирох дараах аргыг ашиглах боломжтой :

- а) ардын болон монголын хөгжмийн зохиолчдоос гадна бусад орны хүүхдийн дууны уран бүтээл сонгох;
- б) хүүхдийн дууны уран бүтээлийг энгийн хөгжмийн зэмсэг дээр тоглож дуулах, хөдөлгөөнтэй дуулах;
- в) хөгжмийн тухай мэдлэг өгөхөд тоглоомын аргыг хэрэглэх;
- г) сайн дуулагдсан хүүхдийн найрал дууны уран бүтээл сонгох, зөв дуулалтыг чихэнд нь хоногшуулах;
- д) сургалтын бүх шатанд бүтээлч даалгаврыг боловсруулах г.м.

Дуулах үйл ажиллагааны явцад хүүхдийн хөгжмийн авьяас чадвар хөгжихөөс гадна тэдний сэтгэл хөдлөл мэдрэмж, оюун ухаан, бие бялдрын хөгжил төлөвшилд нөлөөлөх боломжтойг дээр дурдсан билээ. Хүүхдэд дуулах соёл бүрэлдэж, дуулах дадал чадварыг эзэмшихэд багшийн оролцоо мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэл онцгой үүрэгтэй болно. Цэцэрлэгийн хөгжмийн багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн боловсролын газар болон бусад мэргэжлийн байгууллагын зүгээс сургалт,

семинарыг зохион байгуулж байгаа нь сайшаалтай ч тулгамдаж буй олон асуудал байсаар байгаа нь ярилцлага, асуулгын явцад ажиглагдсан. Асуудлыг тодруулах зорилгоор авсан судалгааны үр дүнг дараагийн хэсэгт хүргэж байна.

Судалгааны үр дүн

Судалгаанд нийслэлийн 50 цэцэрлэгийн хөгжмийн багш нар оролцсон болно.

Асуулгын чиглэлийг дурдвал:

- багш нарын сургалтад хамрагдсан байдал, төгссөн сургуулийн тухай мэдээлэл, нас;
- хөгжмийн багш нарын сургалтад ашиглаж буй хөтөлбөр баримт бичиг;
- хүүхдийн хоолойн эрүүл ахуй, цараа, дуугаралтын онцлогийн талаарх ойлголт;
- хүүхдийн дуулах ур чадварын тухай ойлголт;
- хүүхдийн хөгжмийн тухай ойлголтыг хэр чухалд үздэг ;
- хүүхдэд зориулсан дууны уран бүтээлийн сонголтын тухай;
- хөгжмийн багш нарт зориулсан дуулах арга зүйн ном сурах бичгийн хэрэгцээ шаардлагын талаарх мэдээлэл.

1. Ажилласан жил, насны хувьд харилцан адилгүй багш нар судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан нийт багш нарын 54 % нь хуучнаар Соёлын Дээд Сургууль, 22 % Хөгжмийн Багшийн Сургууль, 8 % Хөгжим Бүжгийн Коллеж, 16 % МУБИС-ийн СӨБС төгссөн байна. Сургуулийн сургалтын чанарт багш нарын ур чадвар, материаллаг орчин, удирдлагын тогтвортой бодлого зэрэг нөлөөлдөг төдийгүй сүүлийн 35 жилийн хугацаанд яамны зүгээс цэцэрлэгийн хөгжмийн багш бэлтгэдэг сургуулиудад бүтцийн өөрчлөлт болон багшлах боловсон хүчний тогтворгүй бодлого явагдсаар байгаа нь төгсөгчдийн ур чадварт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Соёлын Дээд Сургууль-СУИС-ийн харьяа соёлын боловсролын сургууль, СУИС-ийн хөгжмийн урлагийн сургууль; Хөгжмийн Багшийн Сургууль-Хөгжмийн багшийн коллеж, Сурган Хүмүүжүүлэх Ухааны Коллеж, дараа нь Соёлын Дээд Сургуультай нэгдсэн; 1992 он хүртэл Цэцэрлэгийн Багшийн Сургуульд хөгжмийн багшийг тусгайлан бэлддэг байсан нь Соёлын сургуультай нэгдсэн г.м.
2. Цэцэрлэгийн хөгжмийн багш нарын сургалтад ашиглаж байсан хөтөлбөр стандартууд нь цаг үеийн шаардлагаар шинэчлэгдсээр байна.
 - Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил

сургалтын программ 1985 он;


- Хүүхдийн цэцэрлэгийн хүмүүжил сургалтын хөтөлбөр 1991 он;
- Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт 2011 он;
- Сургуулийн өмнөх боловсролын бага, дунд, ахлах бүлгийн хөтөлбөр 2013 он;
- СӨБ-ын цөм хөтөлбөр батлагдан 2015-2016 онд мөрдөгдөж эхэлсэн.

Цөм хөтөлбөр нь багш өөрийн хөгжмийн хөтөлбөрийн хувилбарыг боловсруулан ашиглах боломж нээгдсэн сайн талтай ч багшийн туршлага, мэдлэг ур чадвараас хамааран чанарын хувьд харилцан адилгүй байна. Ихэнх багш нар шинэ “Цөм хөтөлбөр”-ийн давуу талыг “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” гэж хариулсан байдаг. Багшийн энэхүү хандлага, ойлголт зөв боловч багш өөрөө дуулах үйл ажиллагааг хэрхэн хүүхдэд ашиг тустайгаар нас, хувийн онцлогийг харгалзан зохион байгуулах арга зүйг эзэмшээгүй тохиолдолд үр дүн багатай болох нь ойлгомжтой. Дуулах үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн хөгжил төлөвшилд нөлөөлөх сургалтын арга, арга барилууд нь бүрмөсөн өөрчлөгдөөгүй. Иймээс хөгжмийн багш нар хүүхдийн хоолойг хамгаалах, дуулах чадвар, дууны урын сангийн сонголт, дуу заах аргачлалыг судлан хүүхэд бүрийг хөгжүүлэхэд анхааран ажиллах хэрэгтэй юм.

3. Хүүхдийн хоолойн эрүүл ахуй түүнийг хамгаалах, хоолойн цараа буюу дээд доод дуулах өнгийн хязгаар, хэрхэн ямар дуугаралтаар дуулах зэрэг нь багшийн мэдвэл зохих чухал ойлголт юм. “Хүүхдийн хоолойн цараа, хоолойн эрүүл ахуйн талаарх таны бодол? Таны ажиллаж буй хүүхдүүд яаж дуулдаг вэ?” гэсэн асуултад диаграмм 1-д харуулснаар хөгжмийн багш нарын хүүхдийн хоолойн эрүүл ахуй, хоолойг хамгаалах тухай 8 % нь дурдсан бол бусад 92 % нь огт хариулаагүй нь энэхүү асуудлыг чухалд тооцдоггүй гэдэг нь харагдаж байна. Хүүхдийн хоолойг хамгаалаагүй тохиолдолд хоолойн аппарат, хоолойн хөвч гэмтэн сөөж цаашлаад дуу хөгжимд дургүй болох хандлага ажиглагддаг. Диаграмм 2-т хүүхдийн хоолойн дээд, доод өнгөний хязгаар буюу хоолойн царааны тухай багш нарын 34% нь хариулсан бол 66% нь хариулаагүй бөгөөд үүнд анхаарч ажилладаггүй байна. Хүүхдийн хоолойн дуугаралт ямар байхыг 54 % нь мэдэж байсан ба 46 % нь энэ талаарх ойлголт бага байгаа нь судалгаанаас харагдсан тул энэхүү асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй.

Диаграмм 1

Хоолойн эрүүл ахуйн талаарх ойлголт



Диаграмм 2


Хоолойн царааны тухай ойлголт



4. Зөв дуулах дадал чадвар нь дуулах соёлын гол ойлголтын нэг юм. Дуулах дадал чадварын тухай багш нарын ойлголт нь харилцан адилгүй байна. Диаграмм 3 дээр харуулснаар 4-7 дуулах дадал чадварын талаар дурдсан 24%, 1-3 дуулах дадал чадвар 50 %, дуулах дадал чадварын тухай хариулаагүй 26% байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Багш бүр хамгийн багадаа 4-5 дуулах чадварын талаарх ойлголтой байж түүнийг хэрхэн яаж зөв ашиглах арга барилыг эзэмших шаардлага байгаа болно.

Диаграмм 3

Дуулах чадварын тухай ойлголт




5. Хүүхдийн нас, хувийн болон хоолойн онцлог, хүсэл сонирхол, тухайн үеийн үйл ажиллагаанд зориулан хүүхдийн дууны урын санг сонгох хэрэгтэй. Дууны урын санг хүүхдийн хоолойн цараа, дуулах боломж зэргийг харгалзан сонгоогүй тохиолдолд хоолойг гэмтээх, дуулах сонирхолгүй болох, өөртөө итгэлгүй болох зэрэг сул тал буй болдог байна. Диаграмм 4-өөс харахад хөгжмийн багш нарын 50 % нь хүүхдийн

дууны урын санг зөв сонгодог хэдий ч, 34 % нь зарим чухал үзүүлэлтийг харгалзан үздэггүй, 16% нь дууны урын санг хэрхэн зөв сонгох талаар ойлголтгүй байгаа нь хүүхдийн хоолойд сөрөг нөлөөг үзүүлэх магадлалтай.

Диаграмм 4


Дууны урын сан, сонголтын тухай ойлголт



6. Хүүхдийн дуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах арга зүйн зөвлөмж ном сурах бичиг, гарын авлага дутагдалтай байгаа нь дараах хариултаас харагдаж байна. Багш нар ихэвчлэн хүүхдийн дууны түүвэр, сургуулийн хүүхдэд зориулсан сурах бичиг, цэцэрлэгийн хүүхдэд зориулсан хөгжмийн арга зүйн ном, цахим мэдээллийн эх сурвалж зэргийг ашиглаж байна. Монгол хэл дээр бага насны хүүхдийн дуулах арга зүйн бие даасан ном зохиол, гарын авлага дутагдалтай байна.

Диаграмм 5.

Дуулах арга зүйн ном, эх сурвалж ашиглаж буй байдал



Судалгааны үр дүнгээс хөгжмийн багш нарт хүүхдийн дуулах үйл ажиллагааг удирдан зохион явуулахад тулгамдаж буй олон асуудал байгаа нь ажиглагдаж байна.

Өгүүллэгийн төгсгөлд эрдэмтдийн үзэл санаа, багш нарын туршлага, судалгааны ажлын үр дүн, ном сурах бичгийн тоймыг үндэслэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжмийн хичээлээр хүүхдэд дууны сургалтыг зохион байгуулах, хүүхдийн дуулах үеийн хоолойтой ажиллах аргачлал, дууны урын сангийн сонголт хийх зарчмын талаарх арга зүйн зөвлөмжийг санал болгож байна.

Санал, зөвлөмж

Хүүхдийн дуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад хөгжмийн багш дараах зүйл дээр анхаарч ажиллах нь зүйтэй:

Хүүхдийн дуу хоолойн эрүүл ахуй:

- 1) хүүхэд бүрийн биеийн хөгжил, дуулах боломжийг харгалзан үзэх;
- 2) хэтэрхий чанга, огцом орилж дуулуулахгүй байх;
- 3) хүүхдийн дэргэд багш өөрөө хэтэрхий чанга орилж ярихгүй, дуулахгүй байх;
- 4) хүүхдийн хоолойн цараанд тохирсон дуу сонгож дуулуулах;
- 5) удаан хугацаагаар дуулуулахгүй байх; (2-5 минут дуулаад завсарлах)
- 6) нэг хичээл дээр 2-3, өглөөлөг өдөрлөг баярын үед 3-5 дуунаас илүүгүй дуулуулах;
- 7) хоолой өвдсөн үед дуулуулахгүй, эмчлэх зөвлөгөөг эцэг эхэд өгдөг байх;
- 8) дуулах орчин хэт халуун бус шороо тоосгүй цэвэр байх;
- 9) хүйтэнд гадаа дуулуулахгүй байх;
- 10) орон зайны хувьд чөлөөтэй амьсгаа авч дуулахаар зогссон эсвэл суусан байх;

Хүүхдийн хоолойн царааны тухайд:

- ✓ сургуулийн өмнөх насны хүүхэд 6 нас хүртлээ ихэвчлэн I октавын до нотноос II октавын до хүртэл буюу нэг октав дуулах боломжтой;
- ✓ 2-4 настай хүүхдийг нэг октавын дууг дуулуулдаг ч хүүхдүүд ихэвчлэн дээд доод өнгөнүүдийг цэвэр зөв өндөрлөгтэй дуулж чаддаггүй;
- ✓ хүүхдийн цараанд тохироогүй дууг буруу өнгөөр дуулуулснаар хөгжмийн сонсгол, хоолойн эрүүл ахуйд муугаар нөлөөлнө;
- ✓ 4 настай 6 настай хүүхдийн хоолойн цараа, дуулах чадвар ижил байж болно;
- ✓ хүүхэд 1-2 өнгө дуулах хоолойн цараатай байж болно. 8-9 өнгийг маш сайн цэвэр дуулах хоолойн цараан багтаамжтай байж болно;
- ✓ зарим хүүхдийн дундаж өнгө “бага октавын ля” байхад, зарим хүүхдийнх “I октавын фа” байж болно;
- ✓ хөгжмийн багш хүүхэд бүрийн хоолойн царааг сонсож тогтоох шаардлагатай;
- ✓ хоолойн царааг харгалзан хүүхдүүдийг хэсэг бүлгээр хуваан ажиллах;
- ✓ хүүхдийн дундаж өнгөнөөс хоёр тийшээ тэлэх байдлаар царааг хөгжүүлэх;
- ✓ Монголын хөгжмийн зохиолчдын хүүхдэд зориулсан уран бүтээлүүд сайхан аялгуутай байдаг ч олон дуу өргөн цараанд бичигдсэн байдаг учраас хөгжмийн болон бүлгийн багш нар дуунд анализ хийж сонгох нь зөв;

Хүүхдийн дууны урын сан нь дараах шаардлагыг хангасан байх:

- 1) хүүхдийн хөгжил, төлөвшилд нөлөөлөхөөр;

- 2) уран сайхны өндөр түвшинд зохиогдсон;
- 3) хүүхдийн нас хувийн онцлог, хоолойн цараанд тохирсон байх;
- 4) дуулах дадал, чадварын түвшинд тохирсон байх;
- 5) агуулга, шинж төрхийн хувьд олон янз байх;
- 6) зохиол болгон дуулах чадварыг дээшлүүлж сайжруулдаг байх;

Дуулах ур чадвар ойлголтод:

- 1) дууны өнгө цэвэр байх (интонаци);
- 2) хэмнэлийн зураглал зөв байх;
- 3) хоолойн цараан дахь өнгөнүүдийг эзэмших; (царааг аажмаар тэлэх)
- 4) зөөлөн дуулж эхлэх;
- 5) амьсгаа зөв авах, гаргах, хуваарилах, (дууны фразаар амьсгааг зарцуулах);
- 6) үгийг тод хэлэх, эгшгийг урт дуулж гийгүүлэгчийг богино тод хэлэх;
- 7) утга санааг ойлгож сэтгэл хөдлөлөө илэрхийлэн дуулах;
- 8) хамтран дуулж байгаа хүүхдийг сонсож хүчдэл, хурдыг тохируулан нийцтэй дуулах;
- 9) хөгжмийн хамсрааг сонсож дуулах;
- 10) багшийн гарын дохилтыг ойлгох г.м.

Дүгнэлт

Дуулах үйл нь хүүхдийн дуртай үйлийн нэг төдийгүй тэдний амьдралын салшгүй хэсэг бөгөөд хөгжмийн авьяас чадвар, оюун ухаан, бие бялдар, сэтгэл хөдлөл, ерөнхий хөгжил төлөвшилд онцгой нөлөө үзүүлдэг болох нь эрдэмтэн судлаачдын судалгаанаас харагдаж байна. Хүүхэд бүр байгалиас өвөрмөц, давтагдашгүй хөгжмийн өгөгдөлтэй төрдөг бөгөөд багшийн мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэлийн тусламжтайгаар хөгжих боломжтой юм.

Хөгжмийн багш нарын хүүхдийн дуу-найрал дууны соёлын талаарх мэдлэг, ойлголтыг асуулгаар илрүүлсэн судалгааны үр дүнгээс дүгнэж хэлэхэд:

1. Бага насны хүүхдийн хоолойн аппарат эмзэг бөгөөд гүйцэд хөгжөөгүй байдаг. Иймээс хөгжмийн багш нар хоолойн эрүүл ахуй, хоолойн царааг анхаарч ажиллахгүй байгаа нь хүүхдийн хоолойн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна;
2. Хүүхдийн хоолойн хүч бага, амархан цуцдаг. Хүүхдийг хэт удаан хугацаагаар олон дуу дуулуулах, чанга дуулуулах зэрэг нь хүүхдийн хоолойн эрүүл мэндэд нөлөөлөх, цаашилбал дуу хөгжимд дургүй болох талтай;
3. Дуулах ур чадварын тухай мэдлэг нь багш тухайн сургалтын явцад ямар зорилго,

- зорилт тавьж ажиллах гол үзүүлэлт болдог. Судалгаанд хамрагдсан багш нарын хүүхдийн дуулах дадал чадварын талаарх ойлголт бага байгаа нь хүүхдийн дуулах соёл, зөв дуулах дадал бүрэлдэхэд сөргөөр нөлөөлж байна;
4. Дууны урын санг сонгохдоо хүүхдийн дуулах дадал чадвар, нас хувийн онцлогийг харгалзан үзэлгүй хүүхэд бүрийг адилтган нэгэн уран бүтээл зааснаар дуулах ур чадварт тодорхой өөрчлөлт гарах боломжгүй юм. Хүүхдийн хүсэл сонирхол, дуулах боломжийг харгалзан үзэх нь тэдний дуулах соёлын суурь бүрэлдэх чухал нөхцөл болдог;
 5. Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн боловсролын газар бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт семинар, бусад олон үйл ажиллагааг зохион байгуулсаар байна. Тэгсэн хэдий ч дээрх асуудал байсаар байгаа нь цэцэрлэгийн хөгжмийн багш бэлтгэдэг сургуулиудад сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд бүтцийн өөрчлөлт болон багшлах боловсон хүчний тогтворгүй бодлого явагдсаар байгаатай холбоотой;
 6. Дуулах үйл ажиллагаа, дуулах соёл, хүүхдийн хоолойг хамгаалах талаар монгол хэл дээрх ном сурах бичиг ховор, багш нарын хэлний мэдлэг боловсролын төвшин харилцан адилгүйн улмаас интернет орчинд ажиллан мэдээлэл боловсруулах чадвар зэрэг нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байна;
 7. Багш хүүхдийн хоолойн эрүүл ахуй, хоолойн цараа, дуугаралтын боломж, дуулах дадал чадварыг харгалзан дууны уран бүтээлийг зөв сонгохоос гадна дуулах үйл явцыг зохион байгуулах дадал, чадвартай байх шаардлагатай байна.

Бага насны хүүхдийн дуулах соёлын суурь бүрэлдэхэд хүүхэд дуулах дуртай болж, ардын дуу хөгжим, монголын болон сонгодог хөгжмийн зохиолчдын дууны уран сантай танилцаж, дуулах үеийн дээр дурдсан энгийн дадал, чадварыг эзэмшдэг.

Цаашид багш нар болон судлаачид хөгжмийн загвар хөтөлбөр боловсруулах, монгол хүүхдийн хоолойн онцлог, хоолойн цараа, дуугаралтын боломжийг судлах, бага насны хүүхдийн дуулах арга зүйн ном сурах бичиг, гарын авлага зөвлөмж боловсруулах тал дээр анхааран ажиллах шаардлага байна.

Ашигласан материал

- Алмазов, Е.И. (1963). О возрастных особенностях певческого голоса у дошкольников, школьников и молодежи. Развитие детского голоса. Москва.
- Буланов, В.Г. (2003). Как пение способствует развитию различных и весьма полезных качеств личности. Екатеринбург.
- Венгрус, Л.А. (2001). Начальное интенсивное хоровое пение: Дис. д-ра иск. Великий Новгород.
- Дон, Кампбелл. (2012). Хүүхдэд хөгжим сонсгож хөгжүүлэн хүмүүжүүлэх нь. Улаанбаатар.
- Мерзлякова, С.И. (2014). Учим петь детей 3-7 лет. Москва.
- Стулова, Г.П. (2002). Теория и практика работы с детским хором. Москв
- Теплов, Б.М. (1985). Психология индивидуальных различий. Москва.
- Sing Dich Gesund.Терапия пением. <http://www.vobu.com.ua/rus/news/view/24685>
- <http://singdichgesund.weebly.com/>.